

[хавсралт]

Тохиролцооны дагуу гэр бүл цуцлалтын танилцуулга

1. Тохиролцооны дагуу гэр цуцлалт гэдэг нь

○ Эхнэр нөхөр хоёр гэр бүл цуцлахаар харилцан санал тохирсоны дүнд гэрлэлтээ цуцлахыг хэлэх бөгөөд эхний шатанд оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ харьяа шүүх газарт энэ тухай мэдэгдэж гэр бүл цуцлалтын мэдүүлгийг авна. Тухайн мэдүүлгийг гэр бүл цуцлалтын өргөдөлдөө хавсарган ойрхон хот дүүргийн засаг захиргаандаа хандаснаар гэр бүл цуцлалтын үйл ажиллагаа эхэлнэ.

2. Тохиролцооны дагуу гэр бүл цуцлалтын хэрэгжих шат дараалал

A. Тохиролцооны дагуу гэр бүл цуцлалтын мэдүүлэг өгөх

① Мэдүүлэг бүрдүүлэхэд шаардагдах бичиг баримт

② Тохиролцооны дагуу гэр бүл цуцлалтын мэдүүлэг 1ш.

- Эхнэр нөхөр хоёр хамт бөглөх бөгөөд, мэдүүлгийн загвар хуудсыг шүүх газраас авч болох ба мөн дэд шүүх газрын иргэдийг хүлээж авах төвийн веб сайт (<http://help.scourt.go.kr>)-наас авч болно.

- Сүүлийн хугацааг утсаар тохиролцоо боломжтой тул мэдүүлэг бөглөхдөө өөрсдийн утасны дугаарыг тодорхой тэмдэглэх ёстой ба утасны дугаар өөрчлөгдсөн бол тэр даруйд шүүх газарт мэдэгдэнэ.

③ Нөхрийн талын ургийн бичиг болон гэрлэлтийг тодорхойлолт 1ш.

Эхнэрийн талыг ургийн бичиг болон гэрлэлтийн тодорхойлолт 1ш.

-Хот дүүрэг хорооны захиргаанаас гаргуулна.

④ Гэр бүл цуцлах мэдүүлэг 3ш.

- Мэдүүлгийн загварыг нь хот дүүрэг хорооны захиргаа болон шүүхийн газраас авч болно.

- Мэдүүлгийн ар нүүрэн дэх зааврын дагуу эхнэр нөхөр хоёр хамт бөглөх бөгөөд “⑤хүүхдийн асран хүмүүжүүлэгч” хэсгийг гэр бүл цуцлах мэдүүлэгт бичихгүй ба шүүхийн тушаал гарсны дараа насанд хүрээгүй хүүхдийн асран хүмүүжүүлэгчээр тодорхойлогдсон хүний нэрийг бичиж тэмдэглэнэ.

⑤ Иргэний үнэмлэхийн тодорхойлолт 1ш.

- Харъя нутаг дэвсгэрийн хууль зүйн албанд зөвхөн харилцан тохиролцооны дагуу гэр бүл цуцлаар хандах тохиолдолд нэмэлт материал болгон тушаана.

⑥ Насанд хүрээгүй хүүхэд (Жирэмсний үе хамаарна. Гэр бүл цуцлалтын талаар тайлбар авсан өдрөөс 3 сар мөн хууль зүйн албанаас тусгайлан

тогтоосон хугацаанд насанд хүрсэн хүүхэд нь хамрахгүй)-тэй гэр бүл нь гэр бүл цуцлах тухай тайлбар авсны дараа хүүхдийн асран хүмүүлэгч нь хэн болохыг тохиролцсон өргөдөл мэдүүл 1ш түүний хуулбар 2ш тушаана. Мөн гэр бүлийн асуудлыг хариуцсан шүүхэд шүүхийн тушаалын хуулбар болон нотолгоо баримт 3ш бүрдүүлэн тушаана. Эхнэр нөхөр хоёр хамт мэдүүлгийг бөглөж гэр бүл цуцлалттай холбоотой тайлбарыг авсан тохиолдолд өргөдөл мэдүүлгийг тогтоосон хугацаанаас 1 сарын өмнө тушааж болох бөгөөд шүүхийн тушаалын хуулбар болон нотолгоо баримтын хамт тушаана. Хүүхдийг асран хүмүүжүүлэх эрхийн талаар хуулийн дагуу шийдэгдээгүй тохиолдолд шуурхайлан гэр бүлийн асуудал хариуцсан шүүх газарт хандан шүүх өргөдлийг өгч хариу бүхий шүүхийн нотолгоо баримтыг тушаана. Тохиролцооны мэдүүлэг хуудас болон шүүхийн шийдвэрийн хуулбарыг хоцорч тушаах эсвэл бүрдүүлээгүй бол тохиролцооны дагуу гэр бүл цуцлалтын зөвшөөрөл нь хойшлогдох болон хэргийг хэрэгсэхгүйд тооцно.

⑥ Эхнэр нөхрийн хэн нэг нь хилийн чандад байх эсвэл хорих газар ял эдэлж байгаа бол:

- Гадаадад оршин суугаа тодорхойлолтын 1ш (төрийн албан байгууллага болон гадаад хэргийн яамнаас гаргуулна) мөн онцгой тодорхойлолт (хорих газар болон байцаах албанаас гаргуулна) 1ш бүрдүүлж тушаана.

② Мэдүүлгийг тушаах шүүх газар

○ Гэр бүлийн баталгаагаар цуцлуулах эхнэр нөхөр хоёр иргэний бүртгэлийн албаны хаяг болон оршин суугаа хаягын харъяа шүүх газарт хоёул хамт очиж мэдүүлгийг бүрдүүлж тушаана.

- Эхнэр нөхөр хоёрын хэн нэг нь хилийн чандад байгаа эсвэл хорих газар байгаа тохиолдолд л гэр бүлийн хэн нэг нь ганцаараа оролцож мэдүүлгийг тушааж тайлбарыг сонсоно. Насанд хүрээгүй хүүхэдтэй тохиолдолд тэр хүүхдийн асран хүмүүжүүлэгчтэй санал нийлж байна гэсэн өргөдөл 1шт, хуулбар 2шт мөн гэр бүлийн асуудлыг хариуцсан шүүх газарт шүүхийн тушаалын хуулбар болон бусад нотолгоо баримт 3 шт мэдүүлгийн хамтаар бүрдүүлж тушаана.

③ Гэр бүл цуцлахтай холбоотой заавар

○ Хууль зүйн байгууллагаас гэр бүл цуцлахтай холбоотой тайлбарыг авах ёстой бөгөөд зааварлагчаас зөвлөгөө авч болно. Түүнчлэн насанд хүрээгүй хүүхдийг асран хүмүүжүүлэх эрхтэй холбоотой зөвлөгөөг авсны дараа зөвлөгөөний дагуу тохиролцож байгаа эсэхээ бичиж тэмдэглэхийг санал болгоно.

④ Гэр бүл цуцлалтыг шийдвэрлэх хугацааг богиносгох болон чөлөөлөх

○ Гэр бүл салахтай холбоотой тайлбарыг авсан өдрөөс хойш насанд хүрээгүй хүүхэд (жирэмсний үе хамрана)-тэй тохиолдолд 3 сар хүртэл, 1- 3 сарын дотор насанд хүрэх хүүхэдтэй бол насанд хүрэх өдөр хүртэл, 1 сарын дараа насанд хүрэх хүүхэдтэй болон бусад тохиолдолд нэг сар хүртэлх хугацаатай хамтран амьдрах хугацааг сунгаж өгөх бөгөөд, энэ хугацаанд хосууд цаашинд хамтран амьдрах боломжгүй гэж үзвэл гэр бүлийн баталгааг цуцлах болно.

○ Өргөдлийг тушааснаас хойш долоо хоногийн дотор сүүлийн хугацааг тогтоох бөгөөд хэрэв ямар нэгэн холбоо мэдээлэл аваагүй бол анх тогтоосон хугацааг хэвээр үлдээх бөгөөд үүний талаар эсэргүйцэл гаргах боломжгүй.

⑤ Тохиролцсоны дагуу гэр бүл цуцлах саналын талаарх шалгалт

○ Заавал эхнэр нөхөр хоёр хамт өөрсдийн биеийн байцаалт (иргэний үнэмлэхийн тодорхойлолт, жолооны үнэмлэх, төрийн албан хаагчийн үнэмлэх болон паспорт зэргийн аль нэг) болон хувийн тамгыг авчран тогтоосон шалгалтын өдрөө ирж оролцох ёстой.

○ Эхний шалгалтын өдөр оролцоогүй тохиолдолд хоёр дахь удаагийн шалгалтын өдөр ирцэнд хамрагдана. Харин удаа дараалан оролцоогүй тохиолдолд мэдүүлгийг хүчингүйд тооцон тохиролцсоны дагуу гэр бүл цуцлах тухай дахин мэдүүлэг бүрдүүлэн шүүхэд хандана.

○ Эхнэр нөхөр хоёр салах хүсэл хэвээр бөгөөд насанд хүрээгүй хүүхэдтэй үед тэр хүүхдийг асран хүмүүжүүлэх эрхийн тухай санал нийлж байгаа гэсэн өргөдөл мөн гэр бүлийн асуудлыг хариуцсан хууль зүйн албаны шүүхийн шийдвэрийн хуулбар 1ш, нотолгоо баримтууд, шалгагдсаны дараа хууль зүйн албанаас тухайн гэр бүлд шүүх шийдвэрийн хуудас 1ш болон тохиролцооны дагуу салах болсон баталгаа баримт мөн гэр бүлийн асуудлыг хариуцсан шүүх газрын шүүх тушаал хуудас 1ш өгөх болно.

○ Тогтоосон хугацаа хүртэл гэр бүл цуцлах тохиролцоонд хүрч чадаагүй бол гэр бүлийн шүүхэд хандаж өргөдөл гаргах ба товлосон хугацаанд ирж шалтгааныг тайлбарлан байцаалт шалгалтын хугацааг дахин сунгаж болно. Гэр бүлийн шүүхийн шийдвэр гарвал шүүхийн шийдвэр болон нотолгоо баримтыг тушаана. Шүүхээс нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох болон цуцлахад товлосон хугацаа хүртэл салах тохиролцооны мэдүүлгийг бүрдүүлээгүй бол салах өргөдлийг хүлээж авахгүй.

○ Хүүхдийн эрх ашгийн төлөө шүүхийн зүгээс хүүхдийн асран хүмүүжүүлэгчтэй

холбоотой тохиролцоонд хүрсэн эсэхийн талаар нэхэмжилэх ба үүнд санал нийлээгүй үед тохиролцооны дагуу салах өргөдлийн хүлээж авахгүй.

○ Тохиролцооны дагуу салж болох шүүхийн тушаалыг авч чадаагүй бол гэр бүлийн асуудлыг хариуцсан хуулийн газарт тусгайлан хууль зүйн дагуу шүүж өгөхийг нэхэмжлэх болон дахин тохиролцооны дагуу салах өргөдлийн мэдүүлгийг өгч асран хүмүүжүүлэгчийг тогтоож өгөхийг нэхэмжилж болно.

Б. Тохиролцооны дагуу гэр бүл цуцлах тухай мэдүүлэх

○ Тохиролцооны дагуу гэр бүл цуцлах тухай шүүхийн шийдвэрийн хүчинтэй хугацаа нь шийдвэр гарсан өдрөөс хойш 3 сар тул салах шаардлагатай гэж үзвэл дээрх хугацааны дотор эхнэр нөхөр хоюул эсвэл хэн нэг нь хот дүүрэг хорооны засаг захиргаандаа салах тухай шүүхийн шийдвэр болон мэдэгдлийн хамт тушаана.

– Салах тухай мэдүүлэг өгөөгүй бол гэр бүлийн баталгаа цуцлагдаагүй гэж үзнэ. Дээрх хугацааг хэтэрсэн тохиолдолд дахин шүүхэд хандан шийдвэр гаргуулж мэдүүлэх ёстой.

– Насанд хүрээгүй хүүхэдтэй бол салах өргөдлийг мэдүүлэхдээ тохиролцооны дагуу салж байгаа нь үнэн болох нотолгоо баримт, шүүхийн шийдвэр болон, бусад нотолгоо баримтуудыг хамтатган хүүхдийн асран хүмүүжүүлэгчийг тогтоолгох мэдүүлгийг хийх ёстой.

Жирэмсний үед тэр хүүхдийн төрсний дараа иргэний бүртгэлд хамруулахдаа тохиролцон салах болсон шүүхийн тушаал болон бусад нотолгоо баримтуудын хамт тушааж асран хүмүүжүүлэгчийг тогтоолгоно.

- Шүүх тушаалыг үрэгдүүлж гээсэн бол: Шүүхийн шийдвэрийн хүчинтэй хугацаа дуусаагүй бол мэдүүдэг өгсөн харьяа байгууллагад хандан дахин гаргуулж болох ба 3 сараас илүү хугацаа хэтэрсэн бол анхны шатлалаас эхлээд дахин баримт материалыг бүрдүүлнэ.

- Шүүхийн шийдвэрийн эхийг шүүх газар 1 жилийн турш хадгалдаг. Салах нотолгоо баримтыг харьяа засаг захиргаандаа мэдэгдэхээс өмнө түүний хуудбарыг хувь хүн тусад нь хадгалах ёстой.

В. Тохиролцооны дагуу гэр бүл цуцлах тухай өргөдлийн буцаалт

○ Шүүхийн шийдвэр гарсны дараа салах шаардлагагүй гэж үзвэл оршин суугаа харьяа хот дүүргийн захиргаанд мэдэгдэл хийхгүй байж болно. Мөн гэр бүл цуцлалтыг хүчингүй болгох хүсэлтээ иргэний бүртгэлийн алба болон оршин суугаа хаягийн хот дүүрэг хорооны засаг захиргаандаа хандан өргөдөл гаргана.

- Шүүхийн шийдвэр нь салах хүсэлгүй гэсэн өргөдлийн өмнө бүртгэгдвэл гэр бүл цуцлалт хүчинтэй хэвээр үлдэнэ.

3. Тохиролцооны дагуу гэр бүл цуцлалтын үр нөлөө

- Гэр бүлийн шүүхээс тохиролцооны дагуу гэр бүл цуцлалтыг зөвшөөрсөн шийюлэр гаргуулж, бүртгэл хийлгэснээр гэрлэлт цуцлагдана
- Гэр бүл саласны дараа ч хүүхдийн асран хүмүүжүүлэх эрх болон үүрэг хариуцлага нь тохиролцооны дагуух салалтаас үл хамааран хэвээр үлдэх бөгөөд насанд хүрээгүй хүүхэд (жирэмсний үе хамрагдана)ийн асран хүмүүжүүлэгч нь шүүхээс тогтоосны дагуу мөн гэр бүлийн асуудлыг хариуцсан шүүх газрын шийдвэрээр тодорхойлогдоно.
- Салах гэж байгаа нөхрийн иргэний бүртгэлийн албаны хаягаас өөр хаягын харьяалалд орохыг хүссэн эхнэр нь салах тухай өргөдлийн хамт хаягийн өөрчлөлт хийх өргөдлийг гаргаж болно.